



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 14

№ 01/33 ДУА-2018/24/СТА-ОИТС Мандагговь хот

Г

Зөрчлийг арилгуулах тухай

7

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Сайхан-Овоо сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь 23,900,000.00 /хорин гурван сая есөн зуун мянга/ төгрөгийн авлагыг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг барахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцоогыг тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах;/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-г /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох арганыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-г /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.4-г /Байгууллага ирээдтэй үүссэн материаллаг буюу насжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Авлагын үлдэгдлийг баталгаажуулж, тооцоо нийлсэн актаар баримтжуулан барагдуулах ажлыг зохион байгуулах.

Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 01-ний дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Сайхан-Овоо сумын Засаг дарга Б.Түвшинбаатар, нягтлан бодогч З.Цэдэнрулам нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫН**

**ӨГСӨН:**  
АХЛАХ АУДИТОР ДИХБАЯР  
4817144213  
ЗЮА0039 9033475

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ЗАСАГ ДАРГА ТҮВШИНБААТАР  
НЯГТЛАН БОДОГЧ З.ЦЭДЭНРУЛАМ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.